

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль анх 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр анх батлагдаж, одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус хуулийн 4 дүгээр зүйлд 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүдэд Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын ойн баярыг, Цагаан сарыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүдэд, Шинэ жилийг 1 дүгээр сарын 1-ний өдөр, Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг 3 дугаар сарын 8-нд, Хүүхдийн баярыг 6 дугаар сарын 1-ний өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярыг 12 дугаар сарын 29-ний өдөр, Их Эзэн Чингис хааны өдрийг Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1-нд, Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийг 11 дүгээр сарын 26-нд, Бурхан багшийн Их дүйчин өдрийг билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15-нд тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тус тогтоосон байна.

1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн /энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүйд тооцсон/ 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэгт “Нийтээр амрах баярын өдөр, долоо хоног бүрийн амралтын өдөр ойрхон тохиосон тохиолдолд долоо хоногийн ажил, амралтын өдрийг Засгийн газрын шийдвэрээр зохицуулж болно” гэж заасны дагуу тэмдэглэн өнгөрүүлж байсан боловч 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тус зохицуулалт тусгагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл, нийтээр амрах баярын өдрүүд нийтээр амрах өдөр буюу амралтын өдөртэй давхацсан тохиолдолд хэзээ тэмдэглэх, уг асуудлыг хэн шийдвэрлэх нь тодорхойгүй байх бөгөөд тухайн ажил олгогчийн хувьд шийдвэрлэх хэм хэмжээ мөн хуульд тусгагдаагүй байна.

Иймд дээрх тодорхойгүй байгаа асуудлыг нэг мөр ойлгомжтой болгох буюу Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд шаардлагатай зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

Тодруулбал, Манай улс өргөн уудам газар нутагтаа хэдэн зууны туршид нүүдлийн мал аж ахуй эрхэлж өдийг хүртэл уламжлагдан ирсэн билээ. Энэхүү уламжлалтай уялдуулан Цагаан сарын баярын өдрүүдээр орон нутагт амьдарч буй аав ээж, садан төрлүүддээ очиж золгох, урин дулааны цаг - Үндэсний их баяр наадмаар (аймаг, сум) хүчит бөхийн барилдаан, мэргэн сурын харваа, хурдан морины уралдаан үзэж наадамлах зэрэг цаг хугацаа нэлээдгүй зарцуулах баярын өдрүүд амралтын өдрүүдэд давхцацсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх асуудал тодорхойгүй байх тул ахуй амьдралдаа нийцсэн зохицуулалтыг хуульд тусгах, эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

2025 оны 05 дугаар 12-ны өдрийн УИХ-03/6068 дугаартай албан бичгээр Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн боловч, санал дүгнэлт ирээгүй болно. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь санаачилсан хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Засгийн газрын

бусад гишүүн, холбогдох байгууллагад хүргүүлнэ” гэж заасан тул хуулийн төслийн талаар түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагаас тусгайлан санал аваагүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ